



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР

С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-211, Нутгийн удирдлагын  
ордон, 7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48090  
Утас: 7059 2494 Факс: (976) 7059 2494  
Цахим шуудан: info@dundgovi.gov.mn  
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2024.03.13 № 04/306

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Захирамж хянасан тухай

Тус сумын Засаг даргын 2024 оны 1 дүгээр улиралд батлан гаргасан нийт 33 захирамжийн эрх зүйн үндэслэлийг хянаж үзэхэд доорх зөрчлүүд илэрч байна.

1.“Ажлын хэсэг байгуулах тухай” А/03 дугаар захирамжид үндэслэсэн Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалыг тус сайдын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам батлах тухай” 86 дугаар тушаалаар хүчингүй болгосон.

2.“Гэрээ байгуулах тухай” А/19 дүгээр захирамжид хүчингүй болсон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үндэслэсэн.

3.“Төсөвт зохицуулалт хийх тухай” А/23 дугаар захирамжид үндэслэсэн сумын Засаг даргын захирамжийн огноо буруу, Засгийн газрын 2024 оны “Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 62 дугаар тогтоол гэх.

4.“Багийн Засаг дарга нарын цалинг шинэчлэн батлах тухай” Б/02, “Засаг даргын орлогчийн цалинг шинэчлэн батлах тухай” Б/03 дугаар захирамжуудад онцгой нэмэгдэл олгох шийдвэрийг үндэслэх.

5. “Улсын нөөцөөс олгосон тусламжийн тэжээлийг хуваарилах тухай” Б/04 дүгээр захирамжид үндэслэсэн Засгийн газрын 2024 оны 63 дугаар тогтоолын нэрийг бүрэн бичих, А дугаартай болгох.


6.“Ч.Оюунцэцэгийг ажлаас чөлөөлөх тухай” Б/05 дугаар захирамжид Хөдөлмөрийн тухай хуулийг үндэслэх шаардлагагүй.

**Захирамжлалын баримт бичгийг стандартын дагуу боловсруулж гаргасан эсэхийг хянан үзэхэд дараах зөрчил дутагдал илэрсэн. Үүнд:**

Б/04 дүгээр захирамжийн хавсралтад хуудас болон хүснэгтийн баганын дугаар өгөөгүй нь Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан журмын 3.2.7, Баримт бичгийн MNS 5140-2:2021 стандартын 5.14 дэх заалтыг зөрчсөн, А/01, А/18 дүгээр захирамжаар баталсан журам, жагсаалтын 1 дүгээр хавсралтад хуудасны дугаар өгөөгүй нь Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан журмын 3.2.7, А/02, А/04 дугаар захирамжийн зүүн, баруун захыг тэгш аваагүй, хэвлэмэл хуудсанд индекс дугаарын зай хэмжээг Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан журмын 4.2.5-д зааснаар дугаарлах, мөн санамжид байгаа мэдээллийн тэмдэглэлийг Баримт бичгийн MNS 5140-2:2021 стандартын 5.22-д зааснаар өгөгдлийг бичих.

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан Баримт бичгийн стандарт болон Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу баримт бичгээ боловсруулж гаргах.

Сумын Засаг даргын батлан гаргасан нийт захирамжийн 6 хувь нь ямар нэгэн алдаатай буюу зөрчлийн шинж байдлыг агуулж байх тул тухайн шийдвэрийн төслийг боловсруулсан албан хаагчдад танилцуулж, зөрчилтэй шийдвэр дахин гаргахгүй байхад анхаарах, шинэчлэн батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомжийг тухай бүр судлан гаргасан алдаа дутагдлыг залруулж зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тус хэлтэст 5 хоногийн дотор нотломжийн хамт хариу мэдэгдэж, цаашид баталж буй шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг оновчтой тодорхойлж ажиллана уу.



Дундговь аймгийн засаг даргын тамгын газар  
Хууль, эрх зүйн хэлтэс  
Хэлтсийн дарга  
Лувсанням Баярсайхан  
2024-03-13 15:32:41